

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх болон энэ эрхийн хүрээнд газрын хэвлийн баялаг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхийн хэрэгжилтийг хангах зорилгоор Байгаль орчинд нөлөөлөх байдлын нөлөөллийн үнэлгээний тухай хуулийг боловсронгуй болгох ажил явагдаж байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны боловсруулж буй Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хэрэгжүүлэх, байгаль орчны мэдээллийн санг өргөжүүлэх, үнэлгээний шинжээчид тавих шаардлагыг нэмэгдүүлж, үнэлгээний чанарыг сайжруулахад чиглэсэн зохицуулалтууд туссан нь сайшаалтай.

Гэсэн хэдий ч хуулийн төсөлд нарийвчилсан, оновчтой шалгуургүйгээр төсөл хөтөлбөрийг ангилах, зарим ангиллын төсөлд тавих байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, түүний хэрэгжилтэд тавих хяналт, төслийн нөлөөлөлд өртөх иргэд, олон нийтийн оролцооны шаардлагыг бууруулах, орон нутгийн захиргааны шийдвэр гаргахад оролцох эрхийг хумих заалт туссан нь хуулийн төслийн Үзэл баримтлалд заасан хууль зүйн үндэслэл буюу Үндсэн хуулийн дээр дурдсан заалт, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоол,¹ Монгол Улсын нэгдэн орсон

¹ Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоол, Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай, 1.4 (30) хэсэг “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхтэй холбогдсон зохицуулалтыг нэмэх”, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530439064421&showType=1>

байгаль орчин,² хүний эрхийн олон улсын гэрээ конвенц, тэдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр өгсөн олон улсын байгууллагуудын зөвлөмжид нийцэхгүй байна.

Тэрчлэн байгаль орчны нөлөөллийн стратегийн, хуримтлагдах, нарийвчилсан үнэлгээний хүрээнд нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх замаар хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх, нөлөөллийг бууруулах, гомдол, хохирол барагдуулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх зэрэг шаардлагыг тусгаагүй нь дор дурдсан олон улсын хүний эрхийн байгууллагуудаас тогтоосон зарчим, дүгнэлт зөвлөмжөөр хүлээсэн үүрэг, амлалтад нийцэхгүй байна. Тодруулбал:

- НҮБ-ын Хүний эрх зөвлөлөөс Universal Periodic Review (UPR)-ын хүрээнд “Ашигт малтмалын үйл ажиллагааны зөвшөөрөл олгох үйл явцад хүний эрх, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, төслийн нөлөөлөлд өртөх бүх хүнийг үнэлгээний үйл явцад үр дүнтэй оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэх”-ийг 2020 онд зөвлөсөн байна.³
- Бизнесийн хариуцлагагүй үйл ажиллагаанаас учирч буй хор хохирол нэмэгдэх болсныг харгалзан НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 17/4 тоот тогтоолоор “Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд” баримт бичгийг баталж,⁴ улс орнуудыг үндэсний хууль тогтоомжоо нийцүүлэх, удирдах зарчмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг уриалсан билээ. Үүний дагуу Засгийн газар 2023 онд Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)-г батлан хэрэгжүүлж байна. Тус төлөвлөгөөнд “Уул уурхай, олборлолт, дэд бүтцийн төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд...олон нийтийн оролцоог хангах” зорилтыг дэвшүүлж, “Байгал орчны үнэлгээний журам”-д хүний эрхийн үнэлгээний шалгуурыг өргөтгөх,⁵ “Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, уул уурхай, олборлолт, хүнд үйлдвэрлэл, зам тээвэр, эрчим хүчний дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэхэд хүний эрхийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх... хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэх” зорилтын хүрээнд “малчид, иргэдийн мэдээлэл авах эрх чөлөөг хангах, хамгаалах талаар уул уурхай, зам, тээвэр, хүнд үйлдвэрлэлийн идэвхтэй бүс нутагт амьдарч, ажиллаж байгаа малчид, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах,

² Нээлттэй нийгэм форум, Бодлогын асуудал №46 “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн төсөл ба Монгол Улсын олон улсын гэрээний нийцэл”, 2024 он, www.forum.mn/product/418055

³ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын талаарх Үндэсний гуравдугаар илтгэлийн мөрөөр өгсөн зөвлөмж №116.45, <https://docs.un.org/en/A/HRC/46/9>

⁴ НҮБ-ын “Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд”, 18 дахь суурь зарчим, chrome-extension://efaidnbmninnibpcapjpcglclefindmkaj/https://www.ohchr.org/sites/default/files/documents/publications/guidingprinciplesbusinesshr_en.pdf

⁵ Бизнес ба хүний эрх үндэсний төлөвлөгөө, Зорилт 10, <https://legalinfo.mn/mn/detail?law-Id=16760201233431&showType=1>

орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангах, хамгаалах зорилгоор тухайн үйл ажиллагааны нөлөөллийн бүсийг тодорхойлох, хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж малчид, иргэдийн мэдээлэл авах эрх чөлөөг хангах талаар төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллага болон аж ахуйн нэгжийн үүрэг, хариуцлагыг сайжруулах арга хэмжээ авахаар тусгажээ.⁶ Монгол Улсын Засгийн газраас НҮБ-ын дээрх зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд 2023 оны 58 дугаар тогтоолоороо “Стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам”, “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний журам”-ыг шинэчлэн баталж, “нийгмийн нөлөөллийн үнэлгээ”-г дээрх бүх төрлийн байгаль орчны үнэлгээний нэг хэсэг болгон баталгаажуулсан билээ.⁷

- Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хороо “Уул уурхайн олборлолтын зөвшөөрлийг олгохоосоо өмнө хүний эрхийн болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх”⁸ зөвлөмжийг 2015 онд өгсөн нь өнөөг хүртэл бүрэн хэрэгжээгүй байна.
- Эмэгтэйчүүдийг Алагчлах Бүх Хэлбэрийг Устгах Конвенцын хороо “Уул уурхайн салбарын нийгэм, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг жендерээр тусгаарласан өгөгдөлтэй байдлаар бие даасан байгууллагаар гүйцэтгүүлэх” зөвлөмжийг 2022 онд Монгол Улсад өгчээ.⁹

Хуулийн төсөлд байгаль орчинд нөлөөллийн үнэлгээний үйл явц дахь иргэдийн оролцоо, мэдэх эрхийг дордуулах эрсдэлтэй заалтууд туссан нь Монгол Улсын Үндсэн хууль, хуулийн төслийн Үзэл баримтлал төдийгүй НҮБ-ын “Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн дээрх зөвлөмж,¹⁰ дор дурдсан хүний эрхийн олон улсын зарчим, зөвлөмжид нийцээгүйг анхаарах нь зүйтэй. Тодруулбал:

- Эмэгтэйчүүдийг Алагчлах Бүх Хэлбэрийг Устгах Конвенцын хороо “Байгалийн нөөцийн менежментийн төлөвлөлт, шийдвэр гаргалтад хөдөө,

⁶ Бизнес ба хүний эрх үндэсний төлөвлөгөө, Зорилт 11, <https://legalinfo.mn/mn/detail?law-Id=16760201233431&showType=1>

⁷ Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоол, Журам шинэчлэн батлах тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16758850092381>

⁸ Committee on Economic, Social and Cultural Rights, Concluding observations on the fourth periodic report of Mongolia, Recommendation 9 (3), E/C.12/MNG/CO/4, <https://docstore.ohchr.org/SelfServices/FilesHandler.ashx?enc=MFIzKPtibrXtudl7XFk%2BqKY2p%2FbNIJhdmgBIe4zYkpu-JLVTNd4GUOnrQrxilbD15j2gdB2tQqF%2BsDQT%2BHQHWmA%3D%3D>

⁹ Committee on the Elimination of Discrimination against Women, Concluding observations on the tenth periodic report of Mongolia, Concluding recommendations 37(d), CEDAW/C/MNG/CO/10, <https://docs.un.org/en/CEDAW/C/MNG/CO/10>

¹⁰ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын талаарх Үндэсний гуравдугаар илтгэлийн мөрөөр өгсөн зөвлөмж №116.45, <https://docs.un.org/en/A/HRC/46/9>

орон нутгийн эмэгтэйчүүдийн үр дүнтэй оролцоог хангах”¹¹ зөвлөмжийг 2022 онд,

- Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хороо “Малчдын эрхийг хөндсөн уул уурхайн зөвшөөрөл олгохоосоо өмнө тэдэнтэй учир утгатай, үр дүнтэй оролцоог ханган зөвлөлдөж байх”, “Уул уурхайн олборлолтын улмаас эрх нь хөндөгдөх бүх талуудыг нөлөөллийн үнэлгээ хийх үйл явцад үр дүнтэй оролцуулах”¹² зэрэг зөвлөмжийг 2015 онд тус тус өгсөн болно.

Санал 1. Энэ удаагийн эрх зүйн шинэчлэлээр эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн зөрчил, түүнээс улбаатай хүний эрхийн бусад зөрчлөөс сэргийлэх гол арга зам болох болох нийгмийн нөлөөллийн үнэлгээг хуульчлах, байгаль орчны нарийвчилсан үнэлгээг төсөл хэрэгжүүлэгч шууд санхүүжүүлдэг өнөөгийн тогтолцоог өөрчилж, Байгаль орчныг хамгаалах сангаас урьдчилан санхүүжүүлж, гарсан зардлыг төсөл хэрэгжүүлэгчээс үл маргах журмаар гаргуулдаг болох зэрэг “зарчмын шинжтэй томоохон” өөрчлөлт хийх. Үүний тулд хуульд зөвхөн нэмэлт, өөрчлөлт оруулах бус “Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тухай хууль” гэсэн анхдагч хуулийн төслийг боловсруулах.

Санал 2. Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүнд үндэслэн тухайн төсөл хөтөлбөрт нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай эсэхийг тухайлан тогтоодог өнөөгийн тогтолцоог хэвээр үлдээх.

Санал 3. Стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний үйл явцад олон нийт, ялангуяа байгаль орчны мэргэжилтэн, судлаач, төрийн бус байгууллага, нэн ялангуяа төсөл хэрэгжих орон нутгийн иргэдийн оролцоог хуульчлахын хамт нарийвчилсан үнэлгээний тайланг багийн иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлэн санал авдаг өнөөгийн зохицуулалтыг хэвээр хадгалах.

¹¹ Committee on the Elimination of Discrimination against Women, Concluding observations on the tenth periodic report of Mongolia, Concluding recommendations 37(e), CEDAW/C/MNG/CO/10, <https://docs.un.org/en/CEDAW/C/MNG/CO/10>

¹² Committee on Economic, Social and Cultural Rights, Concluding observations on the fourth periodic report of Mongolia, Recommendations 8.C (3) and 9(4), E/C.12/MNG/CO/4, <https://docstore.ohchr.org/SelfServices/FilesHandler.ashx?enc=MF1zKPtibrXtudl7XFk%2BqKY2p%2FbNlJhdmgBIe4zYk-puJLVTNd4GUOnrQrxilbD15j2gdB2tQqF%2BsDQT%2BHQHWmA%3D%3D>

Санал 4. Хуулийн төсөл боловсруулах явцад тавигдах нээлттэй байдал, олон нийтийн хэлэлцүүлгийн шаардлагыг хэрэгжүүлж, хуулийн төслийг түүний бүрдүүлбэрийн хамт цахим хуудаст байршуулж, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх талууд, ялангуяа уул уурхай, дэд бүтцийн төсөл хөтөлбөр хэрэгжиж буй орон нутгийн иргэдэд хуулийн төслийг тухайлан танилцуулж, тусгайлсан хэлэлцүүлэг явуулахад анхаарах.¹³ Тэрчлэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (БОНБҮТХ) нь хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхолд шууд холбоотой тул Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу нээлттэй сонсгол зохион байгуулах замаар хуулийн төслийг олон нийтэд танилцуулж, санал шүүмж өрнүүлэх нь зүйтэй. Учир нь сүүлийн жилүүдэд Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт, тэр дундаа олон нийтийн хэлэлцүүлэг зохих ёсоор явагдахгүй байгааг судалгааны дүн харуулж байна.¹⁴

ТУСГАЙ САНАЛ, ШҮҮМЖ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчлэлийг зөвхөн нэмэлт, өөрчлөлтийн хэмжээнд хязгаарлахгүйгээр хүний эрхийн зөрчлөөс сэргийлэхэд байгаль орчин, нийгмийн нөлөөллийг цогцоор үнэлж, оновчтой төлөвлөх дэлхийн чиг хандлага, хүний эрх, байгаль орчны олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг амлалт, олон улсын байгууллагуудаас манай улсад тусгайлан өгсөн зөвлөмж зэргийн хүндэтгэн хэрэгжүүлэх шаардлагыг харгалзан Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах санал дэвшүүлж байгааг дээр тодорхой дурдсан билээ.

¹³ OECD (2025), Getting the Public on Side: How to Make Reforms Acceptable by Design, OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/262255fd-en>.

¹⁴ Нээлттэй нийгэм форум, “Хууль тогтоомжийн төслийн ил тод байдал ба олон нийтийн хэлэлцүүлгийн шаардлагын хэрэгжилт” судалгааны тайлан, 2025 он, <https://forum.mn/product/459176>

Анхдагч хуулийн төсөлд анхаарах зарим асуудлыг өнөөгийн эрх зүйн орчинд суурилан тодорхойлох үүднээс энэхүү тусгай санал шүүмжийг боловсруулав.

№	Санал	Үндэслэл, тайлбар
Хуулийн зорилт		
1	<p>БОНБҮТХ-ийн 1 дүгээр зүйлийн 1.1-д заасан хуулийн зорилтыг дараах байдлаар өөрчлөх:</p> <p><i>“Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулахад оршино”.</i></p>	<p>Хуулийн төслийн Үзэл баримтлалд Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 хэсгийг хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл хэмээн тодорхойлсон болно.</p> <p>Тэрчлэн Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 30 дахь хэсэгт Үндсэн хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд БОНБҮТХ-д нэмэлт өөрчлөлт оруулахаар тусгасан болно.</p> <p>НҮБ-ын “Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд”, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй.</p>
Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний талаар		
2	<p>БОНБҮТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь хэсэгт заасан “Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ”-ний хууль зүйн тодорхойлолтод дараах агуулгыг нэмж тусгах:</p> <ul style="list-style-type: none"> - Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг бүс нутаг, сав газар төдийгүй баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэл зэрэг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд хийх боломж бүрдүүлэх. - Тэрчлэн хэд хэдэн дэд төслөөс бүрдэх нэг төслийн нөлөөллийг цогц байдлаар нэгтгэн үнэлэх боломж бүрдүүлэх. - Хуримтлагдах нөлөөлөлд шууд болон дам (шууд бус) нөлөөллийг хамруулах. 	<p>БОНБҮТХ-д хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээг тодорхой “бүс нутаг, сав газар”-т хийхээр заасан нь практикт дараах хүндрэл үүсгэдэг. Бүс нутаг гэдэг ойлголт өөрөө тодорхойгүй, практикт нэг баг, нэг сумыг бүс нутаг гэж Төв аймгийн Заамар сумын Төмстий баг, Сэлэнгэ аймгийн Ерөө, Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан, Өмнөговь аймгийн Гурвантэс, Цогтцэций гэх мэт уурхай, баяжуулах үйлдвэрийн хэд хэдэн төсөл нэгэн зэрэг хэрэгждэг сум, багийн хэмжээнд хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх боломжгүй байна.</p> <p>Оюу толгой, Таван толгой зэрэг томоохон төслийн хүрээнд уурхайгаас гадна баяжуулах, боловсруулах үйлдвэр, нисэх онгоцны буудал, цахилгаан станц, авто болон төмөр зам зэрэг олон дэд төсөл хэрэгждэг. Гэтэл тухайн төслийн нийт нөлөөллийг нэгдсэн байдлаар үнэлэх эрх зүйн орчин бүрдээгүйгээс байгаль орчны үнэлгээг салангид байдлаар тус тусад нь хийж иржээ.</p>

№	Санал	Үндэслэл, тайлбар
4	<p>БОНБҮтХ-ийн 6 дугаар зүйлд “Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланд холбогдох сав газрын захиргааны саналыг тусгана” гэсэн заалт нэмэх.</p>	<p>Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнд сав газрын захиргааны оролцоог хангах нь үнэлгээний чанар, ач холбогдлыг нэмэгдүүлж, дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулах ач холбогдолтой. Учир нь сав газрын захиргаа нь тухайн сав газарт хэрэгжүүлэх, менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг хариуцах үндсэн субъект болохын хувьд сав газрын хэмжээнд ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж, иргэн, хуулийн этгээдэд ус ашиглуулах дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлдэг.</p>
5	<p>БОНБҮтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.3-т хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ зайлшгүй хийх үндэслэл буюу тодорхой нөхцөл байдал, эсхүл тогтмол хугацаанд, давтамжтайгаар хийх шаардлагыг тусгах. Ингэхдээ байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага өөрийн санаачилгаар болон орон нутгийн захиргаа, иргэд, төрийн бус байгууллагын хүсэлтийн үндсэн дээр хийх боломж бүрдүүлэх.</p>	<p>Хуулийн 6.3-т хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх шийдвэрийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргахаар заасан боловч уг шийдвэрийг гаргах үндэслэл буюу ямар нөхцөл байдал үүссэн тохиолдолд зайлшгүй хийх, эсхүл тогтмол хугацаанд тодорхой давтамжтайгаар хийх эсэхийг зохицуулаагүй байна. Үүнээс шалтгаалж хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний шаардлага анх 2012 онд хуульчлагдсанаас хойш ердөө 4 удаа хийгдсэн нь нэн хангалтгүй юм. Иймд орон нутгийн удирдлага, иргэд, төрийн бус байгууллагын үндэслэл бүхий хүсэлтийг харгалзан хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийдэг байх нь зүйтэй.</p>
Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний санхүүжилт		
6	<p>Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх:</p> <ul style="list-style-type: none"> - БОНБҮтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.5-д “хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг төрөөс урьдчилсан санхүүжүүлж, гарсан зардлыг төсөл хэрэгжүүлэгч болон эсхүл гэм буруутай этгээдээс учруулсан сөрөг нөлөөллийн хэмжээ, цаф хүрэнээс хамаарч хувь тэницүүлэн үл маргах журмаар гаргуулах”, - БОНБҮтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт “төсөл хэрэгжүүлэгч байгаль орчны нөлөөллийн үнэлгээний зардлыг тусгай дансанд төвлөрүүлж, гарсан бодит зардлын зөрүүг үл маргах журмаар санд нөхөн төвлөрүүлэх” зохицуулалтыг нэмж тусгах. 	<p>Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний хэрэгжилт болон нарийвчилсан үнэлгээний чанар сул байгаагийн шалтгаан нь санхүүжилтийн асуудал юм. Иймд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хараат бус байдлыг ханган чанарыг сайжруулахын тулд санхүүжилтийн тогтолцоог шинэчилж, байгалийн нөөц ашигласны төлбөрийн тодорхой хувийг Байгаль орчныг хамгаалах санд төвлөрүүлэх замаар үнэлгээний зардлыг төрөөс урьдчилан санхүүжүүлж, гарсан бодит зардлыг төсөл хэрэгжүүлэгчдээс үл маргах журмаар гаргуулдаг байх.</p>

№	Санал	Үндэслэл, тайлбар
		Тухайлбал, Норвеги, ¹⁵ Канад, ¹⁶ Герман, ¹⁷ Энэтхэг болон Өмнөд Африкийн зарим бүс нутагт засгийн газар байгаль орчны үнэлгээний зардлыг төвлөрсөн санд цуглуулж, үнэлгээ эрхлэгчдэд төлдөг. Энэ нь үнэлгээг төсөл хэрэгжүүлэгчийн нөлөөллөөс хамгаалах, үнэлгээний бие даасан байдлыг хангах зорилготой. Засгийн газрын удирддаг санг ашигласнаар ил тод байдлыг хангаж, үнэлгээний үйл явцыг ашиг сонирхлыг зөрчлөөс сэргийлэх ач холбогдолтой.
Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ		
7	БОНБҮтХ-ийн 7 дугаар зүйлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг заавал биелүүлэх шинжтэй болгон тодорхойлж, хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуульд тусгах.	Ерөнхий үнэлгээний дүгнэлт нь үүрэг болгосон буюу заавал биелэгдэх шинжгүй тул аж ахуйн нэгжүүд нарийвчилсан үнэлгээг заасан хугацаанд хийдэггүй, зөвлөмжийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган бүрэн хэрэгжүүлдэггүй, хэрэгжүүлээгүйн төлөө хариуцлага хүлээдэггүй.
8	<p>БОНБҮтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулах:</p> <p><i>“Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн хий, газрын тос болон ашигт малтмал хайх тусгай зөвшөөрөл авахын өмнө, сонгон шалгаруулалтын журмаар тусгай зөвшөөрөл авсан бол уг зөвшөөрөл авсны дараа, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ”.</i></p>	<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай болон Ашигт малтмалын тухай хуулийн хоорондын зөрүүнээс шалтгаалан хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх эсэх, хэрэв хийх бол тусгай зөвшөөрөл авахын өмнө эсхүл дараа нь хийх талаар маргаан үүсдэг.</p> <p>Үүнээс шалтгаалан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хайгуулын шатанд ерөнхий үнэлгээ огт хийхгүй байх тухай заалт тусгагдаад байгаа болно.</p> <p>Тодруулбал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (хуучин нэрээр)-наас 2023 онд нийтэд танилцуулсан хуулийн төслийн 18 дугаар зүйлд байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хайгуулын үйл ажиллагаа явуулж дууссаны дараа, ашиглалтын үйл ажиллагаанд бэлтгэх хүрээнд хайгуулын үр дүнгийн тайлан, ашиглалтын үйл ажиллагааны ТЭЗҮ</p>

¹⁵ Норвеги Улс, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний удирдамж, [chrome-extension://efaidnbmn-nnibpcajpcglclefindmkaj/https://www.regjeringen.no/globalassets/upload/kilde/md/bro/2003/0001/ddd/pdfv/182783-t-1428_e.pdf?utm_source=chatgpt.com](https://www.regjeringen.no/globalassets/upload/kilde/md/bro/2003/0001/ddd/pdfv/182783-t-1428_e.pdf?utm_source=chatgpt.com)

¹⁶ Justice Laws Website, Government of Canada, Impact Assessment Act, https://laws.justice.gc.ca/eng/acts/i-2.75/index.html?utm_source=chatgpt.com

¹⁷ ХБНГУ-ын Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль, <https://www.fao.org/faolex/results/details/en/c/LEX-FAOC088976/>

№	Санал	Үндэслэл, тайлбар
		<p>боловсруулсны дараа хийхээр тусгасан болно.¹⁸ Энэ нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг дордуулах эрсдэлтэй тул хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ерөнхий үнэлгээтэй холбоотой үүрэг хариуцлагыг энэ хуулиар зайлшгүй тодотгон баталгаажуулах нь зүйтэй.</p>
Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ		
9	<p>БОНБҮтХ-ийн 8 дугаар зүйлд “байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх бүхий этгээд төсөл хэрэгжүүлэхээс өмнө, ашигт малтмал, газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл авахын өмнө, сонгон шалгаруулалтын журмаар тусгай зөвшөөрөл авсан бол тусгай зөвшөөрөл авсны дараа тухайн төслийн батлагдсан техник-эдгийн засгийн үндэслэлд тулгуурлан хийнэ.” гэсэн заалт нэмэх.</p>	<p>Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хэзээ хийхийг хуулиар нарийвчлан тогтоогоогүй нь маргаан дагуулдаг. Тэрчлэн Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэх өргөдөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан хавсаргах, 39 дүгээр зүйлд ашиглалтын тусгай зөвшөөрөл авахын өмнө, сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл авсан этгээд тусгай зөвшөөрөл авсны дараа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийнэ гэж заасан боловч яг “нарийвчилсан үнэлгээ” гэж тухайлан заагаагүй.</p> <p>Иймд ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаанд “нарийвчилсан үнэлгээ” зайлшгүй хийх, ингэхдээ тусгай зөвшөөрөл авсан арга замаас хамааран тусгай зөвшөөрөл авахын өмнө эсхүл дараа нь хийхийг тодорхой болгох нь зүйтэй.</p> <p>Төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлоход үйл ажиллагаа, үргэлжлэх хугацаа, цар хүрээ, хамгийн гол нь техник, технологийн шийдлүүд нэн чухал учраас нарийвчилсан үнэлгээг тухайн төслийн ТЭЗҮ эцэслэн батлагдсаны дараа хийх нь зүйтэй.</p>

¹⁸ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, 2023 он, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, 18 дугаар зүйлийн 18.3 ба 18.5 дахь хэсэг, chrome-extension://efaidnbmnnnibpcajpcglclefindmkaj/https://mmhi.gov.mn/wp-content/uploads/2023/05/09_05_2023-%D0%A5%D1%83%D1%83%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%82%D3%A9%D1%81%D3%A9%D0%BB-%D0%90%D0%9C%D1%82%D0%A5.pdf

№	Санал	Үндэслэл, тайлбар
10	Хуулийн 8 дугаар зүйлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийхэд зарцуулах хугацааны доод хэмжээг хуульчлах.	Тухайн төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бүх талаас бүрэн дүүрэн үнэлэн тодорхойлох, үнэлгээний чанарыг сайжруулах зорилгоор нарийвчилсан үнэлгээнд зарцуулах хугацааны доод хэмжээг хуулиар тодорхойлох. АНУ гэх мэт орнуудад доод тал нь 2 жил гэх мэт хугацаа заасан байдаг нь үнэлгээний чанарыг сайжруулах зорилго, ач холбогдолтой байна.
Төсөл, хөтөлбөрийн ангилал		
11	<p>Хувилбар 1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эсэхийг ерөнхий үнэлгээний дүгнэлтийг үндэслэн төсөл тус бүрээр тухайлан тодорхойлдог өнөөгийн зохицуулалтыг хадгалж үлдэх. Үүний тулд БОУАӨЯ-ны боловсруулж буй хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг хасах.</p> <p>Хувилбар 2. Хууль тогтоогч дээрх саналыг хүлээн авах боломжгүй гэж үзсэн тохиолдолд төслийн ангилал тогтоох шалгуур үзүүлэлтийг хуулиар зайлшгүй нарийвчлан тогтоох.</p>	Хуулийн төсөлд төсөл, хөтөлбөрийг байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн хэмжээнээс нь хамаарч тодорхой ангилал тогтоохоор заажээ. Гэвч энэхүү ангиллыг тогтооход баримтлах шалгуур үзүүлэлтийг тусгаагүй бөгөөд хожим Засгийн газрын батлах журмаар зохицуулахаар үлдээжээ. Иймд нарийвчилсан шалгуур үзүүлэлтийг олон улсын стандарт, сайн туршлагад үндэслэн хуулиар нарийвчлан тодорхойлоогүй нөхцөлд ийнхүү ангилал тогтоох боломжгүй юм. Учир нь уг ангиллаас хамаарч төсөл, хөтөлбөрүүдэд байгаль орчны үнэлгээ, хяналт, олон нийтийн оролцооны хувьд ялгамжтай шаардлага тавигдахаар байна. Тухайлбал, III ангиллын төсөлд байгаль орчны үнэлгээ болон орон нутгийн иргэдээс санал авахыг шаардахгүй гэх боловч энэ ангилалд ямар төсөл, хөтөлбөр хамаарах нь тодорхойгүй байгаа нь эрсдэлтэй.
12	<p>Дээрх саналтай холбоотойгоор Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дор дурдсан заалтуудыг дараах байдлаар өөрчлөх болон хасах. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан БОНБҮтХ-ийн 3.1.12-т шинээр нэмэх заалтыг хасах. - Хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан БОНБҮтХ-ийн 3.1.4-т өөрчлөлт оруулах саналын “зэрэглэл I, зэрэглэл II” гэснийг хасах. - Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан БОНБҮтХ-ийн 6.7-д шинээр нэмэх заалтыг хасах. - Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан БОНБҮтХ-ийн 7.9, 7.10, 7.11, 7.12-т шинээр нэмэх заалтуудыг хасах. - Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан БОНБҮтХ-ийн 8.9-д шинээр нэмэх заалтыг хасах, 8.10-т шинээр нэмэх заалтаас “<i>Үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээс бусад</i>” гэснийг хасах. 	

№	Санал	Үндэслэл, тайлбар
	<ul style="list-style-type: none"> - Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан БОНБҮТХ-ийн 9.3-т өөрчлөлт оруулах заалтаас “энэ хуулийн 7.9-д заасан ангиллаас хамааран 10 жил хүртэлх хугацаагаар” гэснийг хасах. - Хуулийн төслийн 2 дугаар зүйлээс “зэрэглэл I, зэрэглэл II” гэснийг хасах. - Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан БОНБҮТХ-ийн 7.3-т өөрчлөлт оруулах заалтаас “энэ хуулийн 7.7-д заасан ангиллын дагуу” гэснийг хасах. - Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан БОНБҮТХ-ийн 7.7-д өөрчлөлт оруулах заалтаас “үнэлгээ хийх төслийн ангиллыг” гэснийг хасах. - Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт тусгагдсан БОНБҮТХ-ийн 18.4-т өөрчлөлт оруулах заалтыг хасах. 	
Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ		
13	<p>БОНБҮТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасан Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг “байгаль орчны төлөв байдлын суурь үнэлгээ” гэж өөрчлөн хууль зүйн тодорхойлолт шинэчлэх.</p>	<p>Энэ үнэлгээг төсөл хэрэгжүүлэгч жил бүр хийх ба суурь үнэлгээний үзүүлэлт болон өмнө жилийн төлөв байдлын үзүүлэлтэд гарсан өөрчлөлтийг тодорхойлсны үндсэн дээр тухай жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулдаг байх шаардлагыг хуульчлах.</p>
14	<p>БОНБҮТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан байгаль орчны төлөв байдлын үнэлгээ нь бие даасан, эрх зүйн үр дагавар бүхий баримт бичиг бус бөгөөд байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний хүрээнд хийгдэх ажиллагаа болохыг тодорхой хуульчлах.</p>	<p>Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний үнэн зөвийг төрийн аль нэг байгууллага шалган тогтоох, батлах зохицуулалт байхгүй буюу уг үнэлгээг буруу, чанаргүй хийсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх боломжгүй. Энэ тохиолдолд хуульд уг үнэлгээг байгаль орчны нөлөөллийн үнэлгээний бие даасан төрөл гэж ойлгогдохуйцаар тодорхойлсон нь ойлгомжгүй байдал үүсгэж байна.</p> <p>Тухайлбал, төлөв байдлын үнэлгээг ийнхүү бие даасан үнэлгээ, эрх зүйн үр дагавар бүхий баримт бичиг гэж ойлгосноос Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах явцад хайгуулын үйл ажиллагааны явцад байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагагүй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх нь зүйтэй гэсэн санал, байр суурь хүчтэй илэрхийлэгдэж байв.</p>

№	Санал	Үндэслэл, тайлбар
		<p>Улмаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хайгуулын үйл ажиллагааны өмнө эсхүл явцад хийхгүй, харин хайгуулын үр дүнгийн тайлан боловсруулсны дараа тухайн ордыг ашиглалтад бэлтгэх хүрээнд хийх зохицуулалт тусгагдаад байгаа болно.¹⁹ Иймд төлөв байдлын үнэлгээ нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээг орлохгүй болохыг энэ хуулиар баталгаажуулах нь зүйтэй байна.</p>
Нийгмийн нөлөөллийн үнэлгээ		
15	<p>БОНБҮТХ-ийн зорилт, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ болон байгаль орчны нөлөөллийн ерөнхий ба нарийвчилсан үнэлгээний тодорхойлолт, тэдгээртэй холбоотой дараах заалтад “нийгмийн нөлөөлөл”-ийг нэмж тусгах:</p> <ul style="list-style-type: none"> - 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, - 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалт, - 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг. 	<p>НҮБ-ын “Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд”²⁰, түүнийг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөө,²¹ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж,²² байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хүрээнд нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагыг хуульчлах.</p> <p>Энэ хүрээнд Засгийн газраас 2023 онд Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмыг шинэчлэн баталж, нийгмийн нөлөөллийн үнэлгээг дээрх байгаль орчны үнэлгээнүүдийн хүрээнд зайлшгүй хийх эрх зүйн суурийг тавьсан болно.</p> <p>Бизнес ба хүний эрхийн Үндэсний суурь үнэлгээний тайланд “Малчин өрхийн эрхийг хөнддөг өөр нэгэн асуудал бол уул уурхайн компаниудын үйл ажиллагаа юм.</p>

¹⁹ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, 2023 он, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, 18 дугаар зүйлийн 18.3 ба 18.5 дахь хэсэг, chrome-extension://efaidnbmnnnibpcajpcglclefindmkaj/https://mmhi.gov.mn/wp-content/uploads/2023/05/09_05_2023-%D0%A5%D1%83%D1%83%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%82%D3%A9%D1%81%D3%A9%D0%BB-%D0%90%D0%9C%D1%82%D0%A5.pdf

²⁰ НҮБ-ын “Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд”, 18 дахь суурь зарчим, chrome-extension://efaidnbmnnnibpcajpcglclefindmkaj/https://www.ohchr.org/sites/default/files/documents/publications/guidingprinciplesbusinesshr_en.pdf

²¹ Бизнес ба хүний эрх үндэсний төлөвлөгөө, Зорилт 10 ба 11, <https://legalinfo.mn/mn/detail?law-Id=16760201233431&showType=1>

²² НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын талаарх Үндэсний гуравдугаар илтгэлийн мөрөөр өгсөн зөвлөмж № 116.73, <https://docs.un.org/en/A/HRC/46/9>

№	Санал	Үндэслэл, тайлбар
		<p>Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдсэн бэлчээрийн доройтол, ундны усны хомсдол зэрэг нь малчдын амьд явах эрх, амьдрах орчноо чөлөөтэй сонгох зэрэг үндсэн хуулиар олгогдсон эрхээ бүрэн эдлэх, уламжлалт нүүдлийн мал аж ахуйгаа эрхлэх боломжгүй болгож байна.</p> <p>Уул уурхай болон дэд бүтцийн төслүүдийн байгаль орчны үнэлгээг хийх аргачлалыг 2013 онд Засгийн газрын 374 дүгээр тогтоолоор баталсан бол одоо болтол нийгмийн нөлөөллийг үнэлэх аргачлалыг боловсруулаагүй байна. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийхгүй гэдэг нь нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор, амьжиргааг нөхөн сэргээх хөтөлбөр байхгүй гэсэн үг юм. Тиймээс тухайн уул уурхай, бүтээн байгуулалтын бүсэд амьдарч буй иргэдийн тэр дундаа малчдын мал маллагааных нь дэд бүтцэд өөрчлөлт гарснаар нийгэм эдийн засгийн ямар эрхүүд нь хөндөгдөх, ямар хохирол учрах зэргийг цогцоор нь тодорхойлж хариу арга хэмжээ авах механизм бүрдээгүй байна. Уул уурхайн компаниудын хариуцлагагүй үйл ажиллагаанаас үүдэн малчид амьжиргаа болсон малаа алдах, химийн хорт бодист хордуулах, ундаалах усгүй болох зэрэг олон тооны хүндрэл бэрхшээлийг даван туулж байна.”²³ гэсэн дүгнэлт хийжээ. Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хороо, Эмэгтэйчүүдийг Алагчлах Бүх Хэлбэрийг Устгах Конвенцын Хорооны нийгмийн нөлөөллийн үнэлгээний эрх зүйн орчныг бүрдүүлэхтэй холбоотой тухайлсан зөвлөмжийг энэхүү баримт бичгийн “Ерөнхий санал, дүгнэлт” хэсгээс тодруулан авч үзнэ үү.</p>
16	БОНБҮтХ-ийн 9 зүйлийн дараа “нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө” гэсэн зүйл шинээр нэмэх	Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журамд заасан нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний цар хүрээг хуулиар баталгаажуулах замаар цаашид тогтвортой хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх.

²³ Гадаад, харилцааны яам, НҮБХХ-өөс хамтран хийсэн Бизнес ба Хүний эрхийн Үндэсний суурь үнэлгээний тайлан, 2020 он, 43 дугаар хуудас, <chrome-extension://efaidnbmninnnibpcajpcglclefindmkaj/https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/BHR-National-Baseline-Assessment-Dec-2020.pdf>

№	Санал	Үндэслэл, тайлбар
Олон нийтийн оролцоо, мэдэх эрх		
17	<p>Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний үйл явц дахь иргэдийн (төслийн нөлөөлөлд өртөх) оролцоо, түүний үр нөлөөг нэмэгдүүлэх, нэн ялангуяа өнөөгийн эрх зүйн орчныг дордуулахгүй байх үүднээс хуулийн төсөл дэх олон нийтийн оролцоотой холбоотой зохицуулалтуудыг эргэн харж, сайжруулан томъёолох. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт заасан БОНБҮТХ-ийн 18.6-д шинээр нэмэх заалтад “Засаг даргад” гэсний дараа “төрийн холбогдох бусад байгууллага” гэж нэмэх. - Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт заасан БОНБҮТХ-ийн 18.7-д шинээр нэмэх заалтад “Засаг дарга” гэсний дараа “төрийн бусад байгууллага, албан тушаалтан” гэж нэмэх. - Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан БОНБҮТХ-ийн 8.4.8-д өөрчлөлт оруулах заалтыг хасах. 	<p>Хуулийн төслийн үзэл баримтлалд зааснаар тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль зүйн гол үндэслэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг буюу эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, энэ эрхийг хэрэгжүүлэхэд мэдэх эрхийг хангахыг хуульчлан баталгаажуулсан.²⁴ Гэтэл хуулийн төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд иргэд саналаа багийн иргэдийн Нийтийн хурлаараа нэгтгэн албан ёсоор уламжлах шаардлагыг халах, ерөөс зарим төслийг иргэдэд танилцуулах, санал авах шаардлагагүй гэж үзэх зэрэг иргэдийн оролцооны одоогийн зохицуулалтыг дордуулсан заалтууд тусгагджээ. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль, хуулийн төслийн Үзэл баримтлалд нийцэхгүй байна.</p> <p>Байгалийн нөөц, баялаг ашиглах шийдвэр гаргах үйл явц, тэр дундаа байгаль орчны нөлөөллийн үнэлгээний явцад төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн иргэд, эмэгтэйчүүдийн оролцоог хангахтай холбоотой олон улсын хүний эрхийн зарчим, гэрээ, холбогдох байгууллагуудаас өгсөн зөвлөмжийг энэхүү баримт бичгийн “Ерөнхий санал, дүгнэлт” гэсэн хэсгээс авч үзнэ үү.</p>
18	<p>Тэрчлэн БОНБҮТХ-ийн хуулийн дор дурдсан заалтуудад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн дараах зохицуулалт нэмж тусгах:</p> <ul style="list-style-type: none"> - Хуулийн 7 дугаар зүйлд ерөнхий үнэлгээний явцад тухайн төсөл хэрэгжих орон нутгийн иргэдэд төслийн болзошгүй нөлөөллийг танилцуулж, санал авах заалт нэмж тусгах, - БОНБҮТХ-ийн 8.4.8-т заасан байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланд багийн иргэдийн Нийтийн хурлын санал, тэмдэглэлийг хавсаргах зохицуулалтыг хэвээр үлдээх. 	

²⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй”.

№	Санал	Үндэслэл, тайлбар
	<ul style="list-style-type: none"> - БОНБҮтХ-ийн 10.4-т заасан “18.4” гэснийг “8.4.8” гэж өөрчлөх. - БОНБҮтХ-ийн 10.5-т “<i>танилцуулж</i>” гэсний дараа “<i>багийн иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлж</i>” гэж нэмэх. - БОНБҮтХ-ийн 18 дугаар зүйлд дараах өөрчлөлт оруулах. Үүнд: <ul style="list-style-type: none"> o “<i>Багийн иргэдийн Нийтийн хурлын тэмдэглэлийг 2 хувь үйлдэж, нэг хувийг багийн иргэдийн Нийтийн хурлын даргад өгнө</i>” гэсэн заалт нэмэх. o Багийн иргэдийн Нийтийн хурал хуралдах боломжгүй нөхцөлд иргэдийн оролцоог хэрхэн хангах тухай зохицуулалт тусгах. o Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй айл өрхийг газрын кадастрын сангийн зураглалд тулгуурлан тодорхойлж, үнэлгээний тайланд хавсаргах шаардлага тусгах. o Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд санал авахын өмнө иргэдэд танилцуулах мэдээллийн агуулга, хэлбэр, хугацаа, хэлэлцүүлгийн арга хэлбэр, хугацаа, үр дүнг баримтжуулах, хүчинтэй эсэхийг тогтоохтой холбоотой үндсэн шаардлагыг тусгах. o Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнд санал авах зохицуулалт тусгах. o 18.3-т заасан стратегийн нөлөөллийн үнэлгээнд санал авах хугацааг уртасгах. 	
Орон нутгийн оролцоо		
19	Газрын хэвлийн баялаг ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан батлахтай холбоотой сум, дүүргийн Засаг даргын эрх хэмжээг энэ хуулиар тодорхойлох.	Ашигт малтмалын тухай хуулийн 12, 38, 39 дүгээр зүйлд зааснаар сумын Засаг дарга ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлах эрхтэй байсныг 2022, 2024 онд тус хуульд орсон өөрчлөлтөөр сулруулж, зөвхөн хайгуулын үйл ажиллагааны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянах, ашиглалтын төслийн хувьд Засаг даргад батлагдсан төлөвлөгөөг зөвхөн хүргүүлэх заалт тусгагдсан.

№	Санал	Үндэслэл, тайлбар
		<p>Иймд ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайланг батлах, хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой сумын Засаг даргын эрх хэмжээг энэ хуулиар баталгаажуулах нь зүйтэй.</p> <p>Тэрчлэн 2019 онд шинэчлэгдэн батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журамд газрын тос, ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг сумын Засаг дарга батлах зохицуулалт байгаа болно.</p>
Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх		
20	<p>БОНБҮТХ-ийн 4 болон 7 дугаар зүйлд Үнэлгээний мэргэжлийн зөвлөл, ерөнхий шинжээч, шинжээч дүгнэлт шийдвэр гаргахдаа ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг гаргах, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдээлэх үүргийг хуульчлах.</p>	<p>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх</p>
21	<p>Үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүд болон ерөнхий шинжээч, шинжээчдийн мэдээлэл, тэдгээрийн хамаарал бүхий, нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг ил тод болгох зохицуулалт нэмж тусгах.</p>	
Хариуцлагыг нэмэгдүүлэх		
22	<p>Хуулийн 17 дугаар зүйлд заасан банк, санхүүгийн байгууллагын үүргийн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар тодорхойлох.</p>	<p>Хуульд зөвхөн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлангийн үнэн зөв байдал, дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ эрхлэгч хуулийн этгээдийн үүрэг хариуцлагыг тодорхойлсон нь хангалтгүй болно.</p>
23	<p>Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн үнэн зөв байдал, чанартай холбоотой Үнэлгээний мэргэжлийн зөвлөл болон ерөнхий шинжээч, шинжээчийн хариуцлагыг хуульчлах.</p>	

Хуулийн шүүмж боловсруулсан:
 ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер
 Д.Эрдэнэчимэг



НЭЭЛТТЭЙ
 НИЙГЭМ
 ФОРУМ

Жамъян гүний гудамж-5/1
 Сүхбаатар дүүрэг
 Улаанбаатар-14240
 Монгол Улс
 Утас: (976) 76113207
 Вэб: www.forum.mn
 И-мэйл: osf@forum.mn